



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/363

Булган сум

┌ Хагас жилийн мал тооллого явуулах тухай ┐

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1,в, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд хагас жилийн мал тооллогыг 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр хүртэл зохион байгуулсугай.

2.Тооллогыг товлосон хугацаанд аймгийн хэмжээнд зохион байгуулан явуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.Тооллогын үр дүнд үндэслэн малын индексжүүлсэн даатгалын нөхөн төлбөр олголтын тооцоолол хийгддэг тул бэлтгэл ажлыг сайтар хангуулж, мөрдөгдөж буй заавар журмын дагуу мэдээлэл цуглуулалтын чанар бодит байдалд анхаарч, тооллогын ажилд томилогдсон албан хаагчдын хариуцлагыг өндөржүүлж, гарч болзошгүй алдаа зэргээс урьдчилан сэргийлж, холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг тооллогын ажлын хэсгийн ахлагч (О.Ундрах)-д даалгасугай.

4.Хагас жилийн малын түүвэр судалгааны аргачлал, маягт заавар, арга зүй нэгдсэн удирдлагаар хангаж, тооллогын явц, сан бүрдүүлэлт, үнэн бодит байдалд хяналт тавьж ажиллахыг Статистикийн хэлтсийн дарга (М.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

5.Хагас жилийн мал тооллогын дүнг 2025 оны 06 дугаар сарын 19-ний дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (О.Ундрах)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025 оны
05 дугаар сарын 28-ны/ний өдрийн
А/363 дугаар захирамжийн хавсралт

2025 оны хагас жилийн мал тооллогыг зохион байгуулах
ажлын хэсгийн бүрэлдэхүүн



Ажлын хэсгийн ахлагч: О.Ундрах (Аймгийн Засаг даргын орлогч)
Ажлын хэсгийн орлогч дарга: М.Мөнхбат (Статистикийн хэлтсийн дарга)
Гишүүд: Ч.Шүрэнцэцэг (Хүнс, хөдөө аж ахуйн газрын
даргын албан түр үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Г.Одсүрэн (Мал эмнэлгийн газрын дарга)
А.Нарантуяа (Статистикийн хэлтсийн ахлах
мэргэжилтэн)
Н.Булганбаяр (Статистикийн хэлтсийн
мэргэжилтэн)
Д.Баттулга ("МИГ" даатгалын захирал)

Нарийн бичгийн дарга: Ц.Батчимэг (Статистикийн хэлтсийн Хөдөө аж
ахуй хариуцсан мэргэжилтэн)